тэтгэвэр тогтоолгоод хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдад авч бай
хөдөл-мөрийн хөлс, орлогын хэмжээг шууд харгалзан тэтгэврийг
ялгаатайгаар олгох журам тогтоосон нь: 1/ Монгол Улсын Үнд
хуулийн "хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдл
эрхэмлэн дээдэлнэ" гэсэн заалтыг; 2/ мөн хуулийн 5 дугаар зүйлі
4-т буй "төр нь үндэсний аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвш
болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгоор нийцүү
эдийн засгаа зохицуулна" гэсэн заалт; 3/ мөн хуулийн 16 дуг
зүйлийн 5-д буй "өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүү
заасан бусад тохиолдолд эд мөнгөний тусламж авах эрхтэй" гэ
заалт; 4/ мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 2-т буй "хүнийг үн
угсаа, хэл, арьсны өнгө, нас хүйс, албан ажил, мэргэжил, хөрө
мөнгө, үзэл бодлоор нь үл ялгаварлах"гэсэн заалт; 5/ мөн хуулийн
дүгээр зүйлийн 1-д буй "төрөөс хүний эрх , эрх чөлөөг хангах
эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүл
хүний эрх, эрх чөлөөг зөрчсөнтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэрг
эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна" гэсэн заалт; 6/ Үнд
хуулийн хавсралтын хуулийн 7 дугаар зүйлийн 3-т буй "хү
эрхийг дордуулсан заалт бүхий хууль болон олон улсын гэ
тэдгээрийн заалтыг Үндсэн хууль хүчин төгөлдөр болсноос хө
хэрэглэхийг хориглоно" гэсэн заалт; 7/ Хүний эрхийн түгээ
тунхаглалын 2, 3, 6, 7, 8, 22, 23 дугаар зүйлийн 3 дахь заалт бо
25 дугаар зүйлийн 1 дэх заалтуудыг тус тус зөрчжээ.

Иймд настан иргэдэд хэт дарамт үзүүлсэн энэхүү хуул
хянан үзэж, зохих шийдвэр гаргахыг хүсье" гэжээ.

**Гурав.** Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөө
Шаравжамцын Батбаяр Үндсэн хуулийн Цэцийн хуралдаанд орол
тайлбарлахдаа: "УИХ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хувьд Үнд
хуулийн Цэцэд өргөдөл гаргагчдыг хүндэтгэж байна. Эдгээр хүн
насны тэтгэвэр багасгасан гэдэг асуудлаар гомдол гаргаж, э
хамгаалуулах зорилго өмнөө тавьжээ. Маргаж буй асуудал
холбогдуулан санал гаргахад:

1. Одоо Монгол Улсад 242 мянган хүн тэтгэвэр авдаг бөгөөд ıгээрийн 43 мянган хүн хөдөлмөр эрхэлж байгаа. Эдгээр тэтгэвэр вагчдад олгох тэтгэврийн сангийн 71 хувь нь нийгмийн даатгалын ıнгаас 29 хувь нь улсын төсвөөс бүрдэг.

2. Өнөө үед ажил эрхлээгүй хөдөлмөрийн насны, ıдөлмөрлөх чадвартай хүмүүсийг ажил албанд ажиллуулах уу?, тгэвэр тогтоолгогсдыг ажиллуулах уу? гэдэг төрийн бодлого бий. ıгээр асуудлыг төрийн бодлогоор зохицуулахын тулд Улсын Их урлаас 1997 оны 12 дугаар сарын 19-нд хууль гаргасан болно. Энэ ууль Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчөөгүй" гэв.

Улсын Их Хурлын даргын 1998 оны 2 дугаар сарын 23-ны рийн 36 дугаар захирамжаар томилогдсон, итгэмжлэгдсэн лөөлөгч Чултэмийн Отгонбаяраас: "Би өнөөдрийн хуралдаанд ргодол гаргагчдыг асуудлыг буруу хандсан гэж үзэхгүй. Энэ талаар ıшүүн Ш.Батбаярын нэгэн адил саналтай байна.

Иргэн Л.Баасанхүү Үндсэн хуулийн Цэцийн хуралдаанд олцож тайлбарлахдаа: "Би Цэцэд хандаж гаргасан өргөдлөө мжиж байна. Энэ хууль бол тэтгэвэр тогтоолгогсдыг дэмжих бус лнийг ялгаварлах буюу тэтгэвэр тогтоолгогсдод хөдөлмөрийн рээгээр ажиллагсдын тэтгэврийг цалин орлоготой гэдгээр хасч, рогдуулах бодлого баримталжээ. Ахмадуудын талаар эвслийн стгийн газраас баримталж буй бодлого, Ерөнхий сайд Энхсайханы хэлсэн үгтэй энэхүү хууль зөрчилдөж, тэтгэвэр тоолгогсдыг хөдөлмөрлүүлэхгүй гэдэг бодлого байгааг харгалзан эжийг хүсье" гэв.

Иргэн Д.Дэмбэрэл Үндсэн хуулийн Цэцийн хуралдаанд олцож тайлбарлахдаа: "Би Цэцэд гаргасан өргөдлөө дэмжинэ. ıний гаргасан өргөдлийн агуулга бол тэтгэвэр тогтоолгосон гэдгээ шахалт үзүүлэх бодлого байгааг анхаарахыг хүсэж. Одоо 43 нгын тэтгэвэр авагчид хөдөлмөрлөж байна. Эдгээр хүмүүсийг өлмөрлөж байна гэдгээр зүй ёсоор авах тэтгэврийг хорогдуулдаг буруу байна" гэв.

Иргэн Д.Цогт-Очир Үндсэн хуулийн Цэцийн хуралдаанд олцож тайлбарлахдаа: "Би өргөдлөө дэмжинэ. Энэ хууль нь тгэвэрт гарсан хүмүүсийн амьдралын нөхцөлийг доройтуулсан, мөн тгэвэр авагчдыг дотор нь ялгаварласан учир Үндсэн хууль зөрчсөн уль болжээ" гэв.

ХЯНАВАЛ:

1. Иргэдийн тэтгэвэр авах эрх нь хуульд заасан болзол, рмыг хангасны үндсэн дээр үүсэх Монгол Улсын Үндсэн хуулиар тлгаажсан эрх мөн тул тэтгэвэр тогтоолгосноос хойшхи хугацаанд дөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа гэдэг үндэслэлээр

тогтоогдсон тэтгэврийг зогсоох, багасгаж хорогдуулах хууль зүй үндэслэлгүй байна.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцээс 1997 оны 4 дүгээ сарын 9-ний өдөр гаргасан 02 тоот дүгнэлтийг УИХ хүлээн авч 199 оны 5 дугаар сарын 2-нд 28 дугаар тогтоол гаргасан, улмаа тэтгэврийн эрх нь хэрэгжиж байгаа төрийн албан хаагч хөдөлмөрий гэрээгээр ажиллагчдын тэтгэврийг зогсоох тухай 1997 оны хуулий зарим заалтыг хүчингүй болгосноор өнөө үед насны тэтгэвэр тогтоолгоод төрийн алба хашиж байгаа эсхүл иргэний эрх зүй гэрээгээр ажиллагсад насны тэтгэвэрээ бүрэн авч байна.

Улсын Их Хурлаас 1997 оны 12 дугаар сарын 19-нд батлса хууль нь насны тэтгэвэр тогтоолгогсдыг ажил, албан тушаал амьжиргааны түвшин, хөдөлмөрийн хөлсөөр нь ялгаатай авч үзэ тэтгэврийг өөр өөр байдлаар олгох үндэслэлийг бүрдүүлжээ.

3. Насны тэтгэвэр тогтоолгоод хөдөлмөрийн гэрээ болон бус хэлбэрээр хөдөлмөр эрхлэх нь тэдний амьжиргааны түвшин, эрэл хэрэгцээ, хөдөлмөрийн эрх, хөдөлмөрийн чадвар, улс, нийгмий хөгжилд хувь нэмэр оруулах хүсэл, зорилго зэрэг олон хүчин зүйлээ шалтгаалж байна.

Эдгээр байдлуудаас үндэслэн үзэхэд Нийгмийн даатгалы сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөл оруулах тухай Монгол Улсын 1997 оны 12 дугаар сарын 19-ни өдрийн хуулийн 1 дүгээр зүйлд буй заалтууд Монгол Улсын Үндсэ хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, мөн хуулийн 16 дугаа зүйлийн 5 дахь хэсгүүдийн заалтуудыг тус тус зөрчжээ гэж үзэ үндэслэлтэй байна. Энэ талаар бичсэн иргэн Л.Баасанхүү, Д.Цог Очир, Д.Дэмбэрэл нарын гомдлыг хүлээн авах үндэслэлтэй байх ту Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйл, Монгол Улсы Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйл, Үндсэ хуулийн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны туха Монгол Улсын хуулийн 31, 32, 33 дугаар зүйлийг удирдлага болго ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжий тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын 19 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуулийн 1 дүгээр зүйлд заас "Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн туха хуулийн 5 дугаар зүйлд дор дурьдсан агуулгатай 5 дахь хэс нэмсүгэй:

1/5 дугаар зүйлийн 5 дахь хэсэг: "5. Өндөр насны тэтгэв авагч хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа бол түүн тогтоолгосон тэтгэврийг дор дурьдсан хувиар олгож тооцно.

1. Тухайн сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилт орлого нь амьжиргааны доод түвшингийн хэмжээг хоёр дахь нэмэгдүүлснээс бага бол 100 хувиар;

2. Тухайн сарын хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлого амьжиргааны доод түвшингийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс бол 60 хувиар;

3. Тухайн сарын хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлого амьжиргааны доод түвшингийн хэмжээг 3 дахин нэмэгдүүлснээс бол 40 хувиар;" гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 14 гээр зүйлийн 2 дахь хэсгийн "Хүнийг ... ажил, албан тушаалаар нь гаварлан гадуурхаж үл болно" гэсэн заалтыг; мөн хуулийн 16 гаар зүйлийн 5 дахь хэсгийн "Иргэд ... өндөр наслах, хөдөлмөрийн двар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад хиолдолд эд мөнгөний тусламж авах эрхтэй" гэсэн заалтыг тус тус эчжээ.

2. Энэхүү дүгнэлтийг Улсын Их Хурлын 1998 оны хаврын улган эхэлснээс хойш 15 хоногт багтаан хянан хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд эмжилсугай.

| | |
|---|---|
| **ДАРГА** | Г.СОВД |
| **ГИШҮҮД** | Л.БААСАН<br>Н.ЖАНЦАН<br>Ж.БЯМБАЖАВ<br>Ч.ЭНХБААТАР |

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

| | | |
|---|---|---|
| 98 оны 3 дугаар<br>ын 27-ны өдөр | Дугаар 03 | Улаанбаатар<br>хот |

**Монгол Улсын ЭБШ хуулийн 362 дугаар зүйл; Прокурорын байгууллагын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 4 дэх хэсэг; Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 177 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх тухай маргааныг шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн Цэцийн хуралдааныг Цэцийн гишүүн Бямбаа даргалж, гишүүдэд Л.Баасан, Н.Жанцан, С.Жанцан тгэгч/, Ж.Бямбажав нар, нарийн бичгийн даргаар Б.Цэндээхүүг ишуулан хийв.

Үндсэн хуулийн Цэцийн хуралдаанд өргөдөл гаргагч иргэ Г.Ганзориг, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Батчулуу нар оролцов.

Нийслэлийн Баянгол дүүргийн иргэн Г.Ганзориг Үндсэ хуулийн Цэцэд хандаж гаргасан өргөдөлдөө: "Улсын Ерөнхи прокурор анхан шатны шүүхийн хуулийн хүчин төгөлдөр тасла шийдвэрлэх тогтоол, шийдвэр, давж заалдах, хяналтын журмаа хэрэг хянан шийдвэрлэсэн аймаг, нийслэлийн шүүхийн магадлал давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн Дээд шүүхий магадлалд эсэргүүцэл бичих тухай Монгол Улсын ЭБШ хуулийн 36 дугаар зүйл, Прокурорын байгууллагын тухай хуулийн 13 дугаа зүйлийн 4, ИХШХШ тухай хуулийн 117 дугаар зүйлийн 2 дах хэсгийн заалт Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн "... тэгш байдлыг хангах нь төрийн үйл ажиллагааны зарчим мөн", 19 дүгээр зүйлий "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц баталгааг бүрдүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хүлээнэ", 56 дугаар зүйлийн "Прокурор шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно" гэсэ заалтуудтай давхардуулан үндэслэлээр зөрчилдсөн гэж үзэж байна. Үнд Прокурор, шүүхтэй харьцах ганцхан нөхцөл нь Үндсэн хуулийн 5 дугаар зүйлд заасанаар прокурор, шүүх хуралдаанд төрийн нэрий өмнөөс оролцох явдал юм. Энэ нь Прокурор зөвхөн шүүх хуралдаа төрийн нэрийн өмнөөс оролцох үүрэгтэй гэж ойлгогдож байга бөгөөд хууль тогтоогч энд шүүхийн таслан шийдвэрлэх тогтоо шийдвэрт эсэргүүцэл бичих тухай ойлголт оруулаагүй байна Прокурорт эсэргүүцэл бичих эрх хэмжээ олгохоор хуульчилсан н Үндсэн хуулиар тогтоосон эрх мэдлийн хүрээнээс хальсан, түүни шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох үүрэгт хамааралгү асуудал болжээ. Ийнхүү шүүхийг прокурорын байгууллага хянал байсан социализмын үеийн хуучин тогтолцоог уламжлал болго батламжилсанаар шүүх прокуророос хараат байдалтай хэвээр үлдээ

Шүүхийн хүчин төгөлдөр таслан шийдвэрлэх тогтоо шийдвэрт эсэргүүцэл бичих эрхийг зөвхөн прокурорт олгосно төрийн шүүхийн үйл ажиллагааны тэгш байдлыг хангах зарчи алдагдаж, төрийг төлөөлж байгаа прокурор нь иргэн хүнээс давуу э эдэлж, асуудлыг өөрийн үзэмжээр шийдвэрлүүлэхээр санал тав боломжтой болж байгаа бөгөөд энэ нь хүний эрх, эрх чөлө зөрчигдөхөд хүргэж байна.

Эрүү, иргэний хэрэгт бичсэн прокурорын эсэргүүцлийг заа шүүх хурлаар хянан хэлэлцэхээр, бусад оролцогчдын өргөдлийг шү зөвхөн хянан үзэж, үзэмжээрээ шийдвэрлэхээр хуульчилсан мэтгэлцэх зарчмыг алдагдуулж байна. Шүүх эрх мэдэл гэ ойлголтод шүүхийн ТШТ, шийдвэрт эсэргүүцэл бичих ажилла хамааралгүй гэж үзэж байна. Иймд хуулийн эдгээр заалт Үнд хуульд нийцсэн эсэхийг хянан шийдвэрлүүлэхээр Монгол Улс

дсэн хуулийн 66 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу өргөдөл гав" гэжээ.

УИХ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Батчулуун Монгол Улсын дсэн хуулийн Цэцэд өгсөн тайлбартаа: "Иргэн Г.Ганзоригийн өлөлд дурьдсан хуулиудын заалт Үндсэн хуультай зөрчилдөөгүй : дараахь тайлбар гаргаж байна. Учир нь: шүүх хуралдаанд лцсон прокурор ямар эрх эдэлж, үүрэг хүлээхийг ЭБШ хууль, ШХШ тухай хуульд тодорхой заасан бөгөөд прокурор шүүх алдааны бусад оролцогчдын нэгэн адил эрх эдэлж байгаагаас биш давуу эрх эдлэхгүй. Прокурор шүүх хуралдаанд нэг тал болон лцож байгаагийн хувьд бусад оролцогчдын адил эрх эдэлж, давж лдах ёстой. Ийм учраас анхан шатны шүүх хуралдаанд оролцсон экурор давж заалдах журмаар эсэргүүцэл бичих эрхийг эдлэхээр Ш хуульд заасан явдал Үндсэн хуулийн заалтад харшлахгүй байгаа но. Прокурор нэгэнт төрийг төлөөлөн шүүх хуралдаанд оролцож гаа тохиолдолд бодит байдал болон хуульд нийцээгүй гэж үзсэн үхийн шийдвэр тогтоолын талаар дуугүй суух эрхгүй гэдгийг льчилж өгсөн нь туйлын зөв. Прокурорын эсэргүүцэл гэдэг нь үхийн үнэн чанартаа оролцогч нэг талын санал хүсэлт юм" гэжээ.

Нэхэмжлэгч иргэн Г.Ганзориг Цэцийн хуралдаанд оролцож эн тайлбартаа "Прокурорын байгууллагын тухай хуулийн 15 гаар зүйлийн 1 дэх хэсгийн 5-д заасанаар Ерөнхий прокурор ийн санаачилгаар анхан шатны болон давж заалдах шатны үхийн хуулийн хүчин төгөлдөр болсон ТШТ, шийдвэрт эсэргүүцэл ихийг хуульчилсан нь, дараа нь энэ заалт ЭБШ хуульд алгаажих үндэс болсноороо Үндсэн хуулийн заалтыг зөрчсөн. Төр, эн хоёр эрхийн хувьд тэгш бус байгаар арилгаж, Прокурорын эргүүцэл бичих давуу эрхийг хүчингүй болгох шаардлагатай" гэжээ.

УИХ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Батчулуун "Шүүхээс иж байгаа шийдвэрт эсэргүүцэл бичихгүй бол утгагүй зүйл юм. экурорын эсэргүүцэл нь шүүхийн ажилд гарч болох алдаат засахад гой ач холбогдолтой учир ЭБШ хуулийн 362, Прокурорын гууллагын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 4, ИХШХШ тухай лийн 177 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн богдох заалтыг зөрчсөн гэх үндэслэлгүй байна" гэжээ.

ХЯНАВАЛ:

Үндсэн хуулийн Цэцийн хуралдааны явцад иргэн Г.Ганзориг, гэд хандсан гомдлын дотроос "Прокурорын давж заалдах эргүүцэл бичихтэй холбоотой" хэсгийг өөрөө татаж авсан бөгөөд ний гомдлын шаардлагын бусад хэсгийг хангах үндэслэл оогдохгүй байна.

Прокурорын байгууллагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 хэсгийн 5 дахь заалтын талаар иргэн Г.Ганзориг Үндсэн хуулийн

Цэцийн хуралдааны явцад хүсэлт гаргасан боловч уг асуудлыг анх тавиагүйгээс маргаан хянан шалгах ажиллагаа үүсээгүй, энэ тал УИХ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс ямар нэгэн тайлбар ирүүлээ тул уг асуудлаар Үндсэн хуулийн Цэц дүгнэлт гаргах боломжгүй үзэв.

Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйл, Монгол Ул Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйл, Үнд хуулийн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны ту Монгол Улсын хуулийн 31, 32, 33 дугаар зүйлсийг удирдлага бол **ДҮГНЭЛТ ГАРГАХ** нь:

1. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 362 дугаар зүйл "Аймаг, нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгч, сум буюу дундын, дүүргийн шүүхийн хуулийн хүчин төгөлдөр болсон тас шийдвэрлэх тогтоолд; Улсын Дээд шүүхийн шүүгч, сум буюу дундын, дүүргийн, аймаг, нийслэлийн шүүхийн анхан ша журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн хуулийн хүчин төгөлдөр тас шийдвэрлэх тогтоол, давж заалдах, хяналтын журмаар хэрэг хя шийдвэрлэсэн аймаг, нийслэлийн шүүхийн магадлал, тогтоол, д заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн Улсын Дээд шүүх магадлалд хэргийн оролцогчийн гомдлоор буюу өөрийн санаачил эсэргүүцэл бичих эрхтэй.

Улсын Ерөнхий прокурор анхан шатны шүүхийн хуул хүчин төгөлдөр таслан шийдвэрлэх тогтоол, давж заалдах хянал журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн аймаг, нийслэлийн шүүх магадлал, тогтоол, давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрл Улсын Дээд шүүхийн магадлалд доод шатны прокурорын сана үндэслэн эсэргүүцэл бичих эрхтэй.", мөн Иргэний хэрэг шү хянан шийдвэрлэх тухай хуулийн 177 дугаар зүйлийн 2 дахь хэсг "Улсын Ерөнхий прокурор давж заалдах болон хяналтын журм хэрэг хянан шийдвэрлэсэн шүүхийн магадлал, тогтоолд доод ша прокурорын саналыг үндэслэн хяналтын эсэргүүцэл бичих эрх гэсэн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлий дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 47 дугаар зүйлийн 1 хэсэг, 56 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг УИХ-ын 1998 оны хаврын чуу эхэлснээс хойш 15 хоногт багтаан хэлэлцэж, хархэн шийдвэрл тухай хариу ирүүлэхийг УИХ-д уламжилсугай.

| | |
|---|---|
| ДАРГА | Ж.БЯМБАА |
| ГИШҮҮД | Л.БААСАН<br>Н.ЖАНЦАН<br>С.ЖАНЦАН<br>Ж.БЯМБАЖАВ |

# МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

| | | |
|---|---|---|
| оны 4 дүгээр н 27-ны өдөр | Дугаар 04 | Улаанбаатар хот |

**Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 235 дугаар тогтоол Монгол Улсын Үндсэн хуулийн 45 дугаар зүйлийн заалтуудыг зөрчсөн эсэх тухай**

Үндсэн хуулийн Цэцийн энэхүү дүгнэлтийг 1998 оны 4 дүгээр н 27-ны өдрийн 13.00 цагт Төрийн ордны 406 дугаар өрөөнд в.

Цэцийн хуралдааныг Л.Басан даргалж, гишүүдэд С.Жанцан, лхаажав /илтгэгч/, Ж.Бямбажав, Ч.Энхбаатар нарын лэхүүнтэй, Цэцийн нарийн бичгийн даргаар Б.Цэндээхүүг дуулан хийв.

Цэцийн хуралдаанд гомдол гаргагч иргэн Ц.Мөнххуяг, Монгол н Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Ашигт малын хэрэг эрхлэх газрын дарга Д.Жаргалсайхан нар оролцов.

Иргэн Ц.Мөнххуяг Үндсэн хуулийн Цэцэд хандаж гаргасан өлдөө: "Ашигт малтмалын тухай, Ашигт малтмалын тухай ийг дагаж мөрдөх журмын тухай хуулиуд хэрэгжих явцад йн газрын 1997 оны 12 дугаар сарын 03-ны 235 тоот тогтоол н нь дээр дурьдсан хуулиудыг ноцтой зөрчсөн байна. Ашигт малын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 р зүйлийн "1997 оны 7 дугаар сарын 1-нээс өмнө олгогдсон улын буюу ашигт малтмал ашиглах хүчин төгөлдөр тусгай эрлийг хууль хүчин төгөлдөр болсноос хойш 3 сарын дотор энэ д заасны дагуу шинэчлэн бүртгэнэ" гэсэн заалтын дагуу аж нэгжүүд 1997 оны 10 дугаар сарын 01-ний дотор лицензийн чилсэн бүртгэл хийлгэх ёстой юм.

Засгийн газар "Нүүрсний уурхайнуудын лицензийг шинэчлэн " тухай 235 дугаар тогтоолыг гаргахдаа Эрчим хүчний тухай йн 4 дүгээр зүйлийн, 7, 15 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн удыг үндэслэсэн нь Эрчим хүчний тухай хуулийн холбогдох удтай зөрчилдөж байна. Ингэснээрээ Засгийн газрын 235 тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн 3 дугаар бүлгийн гаар зүйлийн заалтуудыг зөрчжээ" гэжээ.

Мөн иргэн Ц.Мөнххуяг Үндсэн хуулийн Цэцэд ирүүлсэн т тайлбар өргөдөлдөө: "Эрчим хүчний тухай хуулийн 4 дүгээр йн 7 дахь хэсэгт Засгийн газрын бүрэн эрхийг тодорхойлохдоо

эрчим хүчний хангамжийн улсын аюулгүйн нөөцийг бүрдүүл захиран зарцуулах эрхтэй гэж заасан байдаг. Эрчим хүчний тух хуулийн 16 дугаар зүйлд эрчим хүчний хангамжийн улсын аюулгүй нөөцийг тодорхойлж өгсөн байдаг. Эрчим хүчний хангамжийн улс аюулгүйн нөөцөд үйлдвэрлэгч, хангагчид нийтлэг хэрэглэдэг тон тоноглол, материал, сэлбэг хэрэгсэл, нүүрс, шингэн түлш зэр нөөц хадгалагдана гэж заажээ.

Энэхүү хуулийн заалтаар бол зөвхөн олборлосон нүүрс бол боловсруулсан шингэн түлш нь эрчим хүчний хангамжийн улс аюулгүйн нөөцөд орох болон хадгалагдах тул нүүрсний орд газр нөөцөд авах үндэслэлгүй юм. Иймд Засгийн газрын 1997 оны 2 дугаар тогтоол нь хуулийн үндэслэлгүй, Монгол Улсын Үндсэн хуу болон бусад хуулиудыг ноцтойгоор зөрчсөн байгаа тул хүчинг болгоно гэдэгт найдаж байна" гэжээ.

Монгол Улсын Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөл Д.Жаргалсайхан Үндсэн хуулийн Цэцэд ирүүлсэн тайлбарт "Тогтоол нь Эрчим хүчний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 7, дугаар зүйлийн 7 дахь хэсгийн заалтуудыг үндэслэн гарсан. Эрч хүчний нөөцөд олборлосон нөөц төдийгүй олборлоход бэлэн б нүүрс орно гэдэг нь тодорхой байна.

Нүүрс нь удаан хугацаагаар хадгалах боломжгүй түр хугацаанд илчлэг чанараа алддаг тул удаан хугацаагаар нөөцл хадгалж болдоггүй. Өвлийн ачаалалтай улирлд эрчим хүч нөөцгүй болох нь улс орны эдийн засаг, хүн амын амьдрах нөхц ноцтой байдал үүсгэж болзошгүй байдлыг харгалзан Засгийн га бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ юм" гэжээ.

Засгийн газрын 1997 оны 12 дугаар сарын 03-ны өдри хуралдаан дээр Сангийн сайд П.Цагаан: "Эрчим хүчний хуульд Ашигт малтмалын тухай хуульд ч ийм заалт байхгүй шүү дээ? Тэг хуулиа өөрчилбөл ясан юм бэ? Хуулиас дээгүүр тогтоол гарга хуучин арга руугаа эргэн орж байна... Хууль биелүүлээгүйн тө Засгийн газар хуультай зөрчилдсөн тогтоол гаргахад хүрч байна ш дээ!..." гэжээ.

Мөн энэ хурал дээр Хууль зүйн сайд Ж.Амарсан "Лицензийн төлбөрөө хугацаанд нь төлөөгүй бол лиценз нь хүчин болж байгаа юм. Лицензээ шинэчлээгүй, төлбөрөө хугацаанд төлөөгүй бол лиценз нь өөрөө автоматаар хүчингүй болчихоод ба зориуд байлгаад байгаа юмыг нь найруулаад, юмаа хураагаад цаа эвхээд, хашаан дотроо зөөгөөд байж болохгүй. Их Хурлаас Засг газрыг хууль зөрчсөнийг хараад хэд хоногийн дараа энэ тогтоо хүчингүй болгоно шүү дээ" гэжээ.

Ерөнхий сайд М.Энхсайхан: " ... Хууль зөрчилдөх процедурын хувьд ингэх ёстой юм. Тэд мөнгөө төлж чадахгүй ба гээд уул нь та нар Засгийн газар дээр тэр мөнгийг нь төлүүлэх

рж ирэх ёстой байсан юм. Би бол зөрчсөн юм олж харахгүй байгаа эм. Хуулийг нь би өөрөө зөрчих вий гэж мөргүүлж харсан юм. 'анцхан болно гэсэн өгүүлбэр байгаа. Нүүрсний ордыг Засгийн газар ахиран зарцуулах бүрэн эрх эдлэх эрхтэй гэж Эрчим хүчний хуулиар айлбарлаж болох юм байна. Захиран зарцуулах эрхээрээ Ашигт алтмалын хуулийн үйлчлэлд хөндлөнгөөс оролцож болно. Болж л айна. Тийм учраас би энэ тогтоолыг гаргахад болно гэж ойлгоод айна" гэжээ.

Засгийн газрын 235 дугаар тогтоолыг үндэслэн Могойн голын үүрсний орды лицензийг олгохоос татгалзсан Геологи уул уурхайн адастрын албаны шийдвэрийг эсэргүүцэн иргэн Ц.Мөнхуяг нийслэлийн шүүхэд хандсан байна.

Нийслэлийн шүүхийн 1998 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн )5 тоот шийдвэрээр иргэн Ц.Мөнхуягийн нэхэмжлэлийг хангасан айна.

Иргэн Ц.Мөнхуяг Үндсэн хуулийн Цэцийн хуралдаанд ролцож тайлбарлахдаа: "Засгийн газар хууль тогтоодог газар биш. ИХ хууль тогтоодог. Засгийн газар нь хуулиа дээдлэн хэрэгжүүхгүй бол хууль ёсыг сахиулах биелүүлэх явцад муугаар нөлөөлөх элно" гэв.

Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгч Д.Жаргалсайхан илсэн хуулийн Цэцийн хуралдаанд оролцож тайлбарлахдаа: Засгийн газрын 235 дугаар тогтоол Ашигт малтмалын хуультай рчилдөөгүй. Хуулийн хугацааг Засгийн газар өөрчилсөн гэж эхгүй байгаа юм. Засгийн газрын тогтоолоор Ашигт малтмалын улийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн гацааг с нг х үнд нь Эрчим хүчний тухай хуулийн холбогдох алту а юм" гэжээ.

ХЯНАВАЛ

Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 12 дугаар сарын 03- й өдрийн "Нүүрсний уурхайнуудын лицензийг шинэчлэн олгох хай" 235 тоот тогтоол нь Ашигт малтмалын тухай хуулийн 18 гаар зүйлийн 6, 8 дахь хэсгийн ашигт малтмал ашиглах лицензийг гцхүү Кадастрын албаны шийдвэрээр олгож байх тухай заалтууд, шигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай улийн 1, 6 дугаар зүйлийн уг хуульд заасан хугацаанд лицензээ нэчлэн бүртгүүлэх, лицензийн төлбөрөө төлөх, хэрвээ энэ гацаанд шинэчлэн бүртгүүлэх өргөдлөө гаргаагүй, төлбөрөө леөгүй бол лиценз хүчингүй болох тухай заалтуудыг тус тус зөрчиж йгаа нь тогтоогдов.

Иймд Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 12 дугаар ын 03-ны өдрийн 235 дугаар тогтоол нь Монгол Улсын Үндсэн улийн 45 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 1 дүгээр зүйлийн 2 дахь

хэсэг, 20 дугаар зүйлийн заалтуудыг тус тус зөрчиж байх тул э
талаар гаргасан иргэн Ц.Мөнхзуягийн хүсэлтийг хүлээн авах
зүйтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйл, Үнде
хуулийн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тух
Монгол Улсын хуулийн 31 дүгээр зүйлийг удирдлага болг
ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Засгийн 1997 оны 12 дугаар сарын 03-і
өдрийн 235 дугаар тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн
дугаар зүйлийн 1-д буй "Засгийн газар хууль тогтоомжид нийцүүл
бүрэн эрхийнхээ дотор тогтоол, захирамж гаргах бөгөөд түү
Ерөнхий сайд, тухайн шийдвэрийн биелэлтийг хариуцсан сайд гарı
үсэг зурна" гэсэн заалтыг зөрчсөн.

2. Энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дот
хянан хэлэлцэж, хариу мэдэгдэхийг Монгол Улсын Их Хура
уламжилсугай.

| | |
|---|---|
| **ДАРГА** | **Л.БААСАН** |
| **ГИШҮҮД** | **С.ЖАНЦАН** |
| | **Д.ЧИЛХААЖАВ** |
| | **Ж.БЯМБАЖАВ** |
| | **Ч.ЭНХБААТАР** |

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 1998 оны 3 дугаар сарын 25-ны өдөр | Дугаар 43 | Улаанбаатар хот |

**Дүрэм батлах тухай**

Даатгалын тухай Монгол Улсын хуулийн 16.1 дүгээр ллийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТООХ нь:

1."Даатгалын хяналтын албаны дүрэм"-ийг хавсралтын ор батлсугай.

2.Даатгалын хяналтын албаны удирдлага, төсөв, орон , бүтэц, зохион байгуулалтыг хянан үзэж түр баталж лүүлэхийг Сангийн сайд П.Цагаанд үүрэг болгосугай.

**Монгол Улсын Ерөнхий сайд** **М.ЭНХСАЙХАН**

**Сангийн сайд** **П.ЦАГААН**

Засгийн газрын 1998 оны 43 дугаар тогтоолын хавсралт

### ДААТГАЛЫН ХЯНАЛТЫН АЛБАНЫ ДҮРЭМ

**Нэг.Нийтлэг үндэслэл**

1.Энэхүү дүрмийн зорилго нь Даатгалын хяналтын аны эрх, үүрэг, үйл ажиллагаа, удирдлага, зохион гуулалтын үндсэн зарчмуудыг тогтоох, даатгалын ай Монгол Улсын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй богдсон харилцаа зохицуулахад оршино.

2.Даатгалын хяналтын алба нь /цаашид "хяналтын а" гэнэ/ даатгалын тухай хууль тогтоомжийг хэрэг-лэх, түүний хэрэгжилтийг даатгалын үйл ажиллагаа элж буй аж ахуйн нэгжид шалгаж зааварчлах, хяналт их, даатгалын үйл ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх аар бодлого боловсруулж шийдвэрлүүлэх үндсэн чиг гийг гүйцэтгэнэ.

3.Хяналтын албаны үйл ажиллагаатай холбогдож гарах длыг төсвөөс санхүүжүүлнэ.

4.Хяналтын алба нь зохих журмын дагуу үйлдсэн дэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

### Хоёр.Даатгалын хяналтын албаны бүтэц, зохион байгуулалт

5.Хяналтын алба нь Сангийн сайдын дэргэд ажиллана.

6.Хяналтын албаны даргыг Сангийн сайдын санал болгосноор Засгийн газар томилж, чөлөөлөх бөгөө дарга нь улсын ерөнхий байцаагч байна.

7.Хяналтын алба нь Бодлого зохицуулалт, лицензийн хэлтэс, Нягтлан бодох бүртгэл, тайлангийн хэлтэс Тамгын хэлтэстэй, Улаанбаатараас бусад аймаг, хото даатгалын улсын байцаагчтай байна.

8.Хяналтын албаны орлогч дарга, Бодлого зохицуулалт, лицензийн хэлтсийн дарга болон Нягтлан бодо бүртгэл, тайлангийн хэлтсийн дарга нар нь даатгалы улсын ахлах байцаагч байна.

9.Хяналтын албанд ажиллах улсын ахлах байцаагч улсын байцаагчийг албаны даргын санал болгосноо Сангийн сайд томилж, чөлөөлнө.

10.Орон нутагт ажиллах улсын байцаагчийг албан даргын санал болгосноор тухайн шатны Засаг дарг томилж, чөлөөлнө.

11.Хяналтын алба нь үйл ажиллагааныхаа чиг үүрэг тэй холбогдуулан орон тооны бус зөвлөл байгуул ажиллаж болно.

12.Хяналтын албаны дарга ажлаа Сангийн сайдын өмн хариуцна.

### Гурав.Хяналтын албаны эрх, үүрэг

13.Хяналтын алба нь энэхүү дүрмийн "Нэг"-ийн 1.2- заасан үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхээс гадн дараахь үүрэг хүлээж, эрх эдэлнэ:

а/хяналтын алба нь даатгалын үйл ажиллагаа эрхлэ тухай бүрдэл болсон хүсэлтийг хүлээж авсаас хой ажлын 21 хоногт багтаан хянаж, зөвшөөрөл /лиценз олгох дүгнэлтээ Сангийн сайдад тавина. Зөвшөөрөл эрхлэх даатгалын төрөл, түүний хэлбэр, давхар даатга эрхлэх эсэх талаар тодорхой заана;

б/даатгалын гэрээний үлгэрчилсэн загварыг батлах хуулиар тогтоогоогүй заавал даатгалын хураамжийн хэм жээ, сайн дурын даатгалын хураамжийн дээд, доо хязгаарыг тогтоож өгөх, түүний мөрдөлтөд хянал тавих;

в/даатгалын компани, даатгалын зуучлагч, төлөөлөг чийн талаар улсын нэгдсэн бүртгэл хөтлөх, даатгалы компанийн санхүү, төлбөрийн чадварын шалгуур үзүү лэлтийг тогтоох;

г/сайн дурын даатгалын төрөл, хэлбэрийг тогтоосон гсаалт гаргах, эд хөрөнгийн зарим эдрэл гэмтлийн кирлын норматив тогтоох;

д/даатгалын статистик судалгаа хийх, мэдээллээр нгах, гадаад, дотоод зах зээлийг судлах, даатгалын хай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, үнийг цаашид боловсронгуй болгох чиглэлээр санал, гнэлт гаргах;

е/даатгалын компаниудаас санхүүгийн улирал, жилийн йлан тэнцэл болон санхүү, төлбөрийн чадвартай холгдсон мэдээ, мэдээлэл, баримт материалыг холбогдох үлийн этгээд, иргэдээс шаардах, үнэ төлбөргүй эгуулан авах;

ж/даатгалын тухай хууль тогтоомжийг зөрчсөн аж үйн нэгж, албан тушаалтанд хуульд заасан үндэслэл, ких журмын дагуу хариуцлага хүлээлгэх;

з/даатгагч, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах, іний санал, хүсэлт, гомдлыг шалгаж барагдуулах;

и/хяналтын алба нь гадаад орны даатгалын байгууллатай хамтран ажиллах, гэрээ, хэлцэл байгуулах, ухэд нэхэмжлэл гаргах;

к/хөндлөнгийн байгууллага, мэргэжлийн хүмүүсийг налт шалгалтад татан оролцуулах, дүгнэлт гаргуулах.

14.Хяналт шалгалтын дүнг үндэслэн улсын байцаагс тавьсан актад улсын байцаагч болон тухайн даатлын компанийн санхүүгийн баримтад нэг, хоёрдугаар эын үсэг зурдаг албан тушаалтнууд, зөрчилд холдох бусад этгээд гарын үсэг зурна:

а/хэрэв хариуцагч нь актыг зөвшөөрөхгүй бол тэр айгаа тайлбар бичиж актад хавсаргана;

б/шаардлагатай гэж үзвэл илэрсэн зөрчил дутагдлын і, шалтгаан, нөхцөлийг харгалзан хяналт шалгалтын іг:

-Сангийн сайдын зөвлөлд;

-Даатгалын хяналтын албаны зөвлөлд хэлэлцүүлэхээр оруулж, зохих шийдвэр гаргуулна.

в/шалгалтын дүнг тухайн даатгалын компанийн ірдлагын зөвлөлөөр хэлэлцүүлж, илэрсэн зөрчил, агдлыг арилгуулах арга хэмжээ авна;

г/даатгалын улсын байцаагч нь шалгалтын дүн, үнтэй холбогдож гарах дүгнэлт,тавьсан актыг тухайн тгалын компанид албан ёсоор хүргүүлнэ;

д/хяналт шалгалтын дүнгээр илэрсэн зөрчил, авах а хэмжээ,актаар тавьсан төлбөрийг тухайн даатгалын

компани тогтоосон хугацаанд нь биелүүлж, хар мэдэгдэх үүрэгтэй.

15.Хяналтын албаны дарга нь өөрийн эрх хэмжээн хүрээнд тушаал гаргах бөгөөд улсын ерөнхий байцаа чийн хувьд даатгалын улсын ахлах болон даатгал улсын байцаагчийн тавьсан актыг хянан үзэж, шаар лагатай тохиолдолд хүчингүй болгох, дүгнэлти өөрчлөх эрхтэй.

**Дөрөв.Даатгалын улсын байцаагчийн эрх, үүрэг**

16."Төрийн хяналт шалгалтын тухай" хуулн 21 дүгээр зүйлд заасан улсын байцаагчийн нийт бүрэн эрхийг хэрэгжүүлэхээс гадна дараахь эрх эдэл үүрэг хүлээнэ:

а/даатгалын үйл ажиллагаатай холбогдсон өргөд гомдлыг барагдуулах;

б/даатгалын тухай хууль тогтоомжийг зөрчсөн ахуйн нэгжийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэх

в/даатгалын компанийн нягтлан бодох бүртгэл улирал, жилийн тайлан тэнцэл болон санхүү, төлбөр чадвартай холбогдсон мэдээ, мэдээлэл, баримт ма риалыг холбогдох байгууллагаас шаардаж үнэ төлбөр гаргуулан авах;

г/баримтын шалгалт хийх.

17.Даатгалын тухай хууль тогтоомж зөрчсөн эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол даатга улсын байцаагч дараахь хариуцлага ногдуулна:

а/зөвшөөрөлгүйгээр даатгалын үйл ажилла эрхэлсэн бол хууль бусаар олсон орлогыг хура 200000-250000 төгрөгөөр торгох;

б/даатгалын тухай хууль тогтоомж, хянал албанаас гаргасан шийдвэрийг зөрчсөн албан тушаалт 10000-50000 хүртэл, компанийг 50000-200000 төгрөг торгох, эсхүл үйл ажиллагааг нь түр зогсоох;

в/даатгуулагчийг хууран мэхэлж, тэдний эрх ашг хохироосон даатгалын компанийн зөвшөөрлийг нь хура

**Тав. Бусад зүйл**

18.Улсын байцаагч үүрэгт ажлаа зохих ёсоор б лүүлээгүй, хууль тогтоомж зөрчсөн бол түүнд холбог хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэх

19.Даатгалын компани, тэдгээрийн удирдлага ул байцаагчийн тавьсан актыг хүлээн зөвшөөрөх үнд лэлгүй гэж үзвэл Хяналтын албаны даргад, Хянал албаны даргын шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй гомдлоо шүүхэд гаргана.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ

998 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр Дугаар 44 Улаанбаатар хот

**Үндэсний архивын байрыг төрийн тусгай хамгаалалтад авах тухай**

рхивын тухай Монгол Улсын хуулийн 19 дүгээр ийн 1, 5 дахь хэсэг болон Төрийн тусгай аалалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь гт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ООХ нь:

. Монгол Улс дахь архивын сан хөмрөгийн хосгүй , үнэт баримт болон кино, гэрэл зургуудыг хадгалж Үндэсний төв архивын байрыг 1998 оны 5 дугаар н 1-ний өдрөөс эхлэн төрийн тусгай хамгаалалтад мг Улсын аюулгүй байдлыг хангах газрын дарга хнасанд даалгасугай.

Төрийн тусгай хамгаалалтад шилжсэнтэй хол-уулан Үндэсний төв архивын байрны жижүүрийн огдох төсөв, орон тоог Улсын Аюулгүй байдлыг ах газрын мэдэлд шилжүүлэхийг Сангийн сайд гаан, Хууль зүйн сайд Ж.Амарсанаа нарт үүрэг осугай.

онгол Улсын Ерөнхий сайд М.ЭНХСАЙХАН

уль зүйн сайд Ж.АМАРСАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ

98 оны 4 дүгээр рын 1-ний өдөр Дугаар 45 Улаанбаатар хот

**Интернэтийн талаар авах зарим арга хэмжээний тухай**

нгол Улсын Ерөнхий сайдын 1997 оны 130 дугаар рамжаар байгуулагдсан интернэтийн асуудлаар эс баримтлах бодлого боловсруулах ажлын хэсгийн

дугнэлт, саналыг үндэслэн Монгол Улсын Засги
газраас ТОГТООХ нь:

1.Төр, захиргааны байгууллагуудыг интернэти сүлжээнд холбох "Галактик Сателлайт Интернэт сист бүхий тоон мэдээллийн нэгдсэн сүлжээ" төслийн хамтр гүйцэтгэгчээр Бодькомпьютер, Датаком ХХК-иудыг сонг авах тухай ажлын хэсгийн саналыг зөвшөөрсүгэй.

2.Техникийн шийдэл, тоног төхөөрөмжийн үнэ, үй чилгээний хөлс, төслийг хэрэгжүүлэх график, оролцо талуудын харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тодорх тусгасан гэрээг хэрэгжүүлэгч компаниудтай байгуу хэрэгжилтэд нь хяналт тавих ажлыг зохион байгуулах Дэд бүтцийн хөгжлийн сайд Г.Нямдаваад даалгасугай.

3.1998 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд ту гагдсаны дагуу уг төслийг санхүүжүүлэхийг Санги сайд П.Цагаанд зөвшөөрсүгэй.

4.Төслийн хэрэгжилтийн явцад бий болох төри өмчийн хөрөнгийг улсын бүртгэлд авч, зарцуулал ашиглалтад хяналт тавьж байхыг Төрийн өмчийн хорос дарга З.Энхболдод даалгасугай.

**Монгол Улсын Ерөнхий сайд** **М.ЭНХСАЙХАН**

**Дэд бүтцийн хөгжлийн сайд** **Г.НЯМДАВАА**

**Сангийн сайд** **П.ЦАГААН**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 1998 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр | Дугаар 49 | Улаанбаатар хот |

**Жагсаалт батлах тухай**

"Ашигт малтмалын тухай" хуулийн 11 дүгээр зүйл 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засг газраас ТОГТООХ нь:

1.Тухайн газар эзэмшигч буюу өмчлөгч нь өөр эзэмшлийн буюу өмчийн газраас өөрийн ахуйн хэрэгцэ ашиг олох зорилгогүйгээр лицензгүйгээр ашиглаж бо ердийн ашигт малтмалын жагсаалтыг хавсралтын ёс батлсугай.

2.Ердийн ашигт малтмалыг лицензгүйгээр ашиглах урам боловсруулан мөрдүүлэхийг Хөдөө аж ахуй, йлдвэрийн сайд Л.Нямсамбуу, Байгаль орчны сайд .Адъяасүрэн нарт, журмын биелэлтэд хяналт тавьж жиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус аалгасугай.

3.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан "Ашигт алтмалын жагсаалт батлах тухай" Засгийн газрын 1995 ны 5 дугаар сарын 24-ний өдрийн 81 дүгээр тогтоолыг үчингүй болсонд тооцсугай.

**Монгол Улсын Ерөнхий сайд** **М.ЭНХСАЙХАН**

**Дэд бүтцийн хөгжлийн сайд**
**бөгөөд Хөдөө аж ахуй,үйлдвэ-**
**рийн сайдын үүрэг гүйцэтгэгч** **Г.НЯМДАВАА**

Засгийн газрын 1998 оны 49
дүгээр тогтоолын хавсралт

**ЛИЦЕНЗГҮЙГЭЭР АШИГЛАЖ БОЛОХ ЕРДИЙН**
**АШИГТ МАЛТМАЛЫН ЖАГСААЛТ**

1.Тоосгоны шавар
2.Элс
3.Хайрга
4.Кварцит
5.Барилгын чулуу
6.Шохойн чулуу
7.Доломит /бадмар/
8.Мергель /баргилт/
9.Магмын чулуулаг
10.Галт уулын чулуулаг
11.Хувирмал чулуулаг
12.Алевролит /зануужин/

-----ooo-----

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1998 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр | Дугаар 51 | Улаанбаатар хот

**"Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг хамгаалах, сэргээн засварлах Үндэсний хөтөлбөр" батлах тухай**

Төрөөс түүх, соёлын дурсгалт зүйлийг хадгалж хамгаалах, сэргээн засварлах талаар баримтлах бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1."Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг хамгаалах, сэргээн засварлах Үндэсний хөтөлбөр"-ийг хавсралтын ёсоор батлсугай.

2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон арга хэмжээ, зардлыг 1999 оноос эхлэн тухайн жилийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн үндсэн чиглэл, төвлөрсөн болон орон нутгийн төсөвт тусган шийдвэрлэж байхыг Сангийн сайд П.Цагаан, Гэгээрлийн сайд Ч.Лхагважав, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

3.Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг Гэгээрлийн яаманд тайлагнаж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан Засгийн газарт мэдээлж байхыг Гэгээрлийн сайд Ч.Лхагважавт тус тус даалгасугай.

**Монгол Улсын Ерөнхий сайд** **М.ЭНХСАЙХАН**

**Гэгээрлийн сайд** **Ч.ЛХАГВАЖАВ**

Засгийн газрын 1998 оны 51
дүгээр тогтоолын хавсралт

## ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙГ ХАМГААЛАХ, СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

### Нэг.Үндэслэл

Монголын ард түмэн өөрийн түүхийн урт хугацаанд үүдлийн өвөрмөц соёл иргэншил, түүндээ зохицсон оёл, урлагийн болон утга соёлын үнэт зүйлс бүтээсэн илээ. Тиймээс олон зуун жилийн туршид уламжлагдан рсэн түүх, соёлын дурсгалт зүйл, утга соёлын өвийг удлан шинжилж, хадгалж хамгаалан хойч үедээ өвлөн элгамжлуулах нь дэлхийн соёл иргэншилд зохих байр ууриа олохоос гадна танин мэдэхүй, түүх, соёл, инжлэх ухааны чухал ач холбогдолтой юм.

Түүх, соёлын дурсгалт зүйлийг хадгалж хамгаалах рх зүйн үндсийг бий болгох, бүртгэх, улс, орон утгийн хамгаалалтад авах, судалж шинжлэх, сэргээн асварлах, сурталчлах зэрэг үйл ажиллагааг 1925 оноос хлэн хэрэгжүүлж иржээ.

Түүх, соёлын дурсгалт зүйлийг сэргээн засварлах эргэжлийн байгууллага 1973 онд байгуулагдаж марбаясгалант, Эрдэнэзуу, Гандантэгчэнлин, Заяын үрээ, Цэцэн хааны ордон, Алтанбулаг дахь түүхт эрилгууд зэрэг 40-өөд нэр төрлийн түүх, соёлын урсгалт барилга, цогцолборуудыг сэргээн засварласан эгээд дээрх түүх, соёлын дурсгалуудыг сэргээн асварлахад төрөөс жил бүр зохих хэмжээний хөрөнгө эргаж санхүүжүүлж байв.

"Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах хууль"-йг 1994 онд шинэчлэн баталж түүх, соёлын дурсгалт үйлийг хадгалж хамгаалах, сэргээн засварлах ажлыг эсын хэмжээнд мэргэжил, арга зүйн удирдлагаар энгах, түүх, соёлын дурсгалт зүйлийн улсын нэгдсэн үртгэл-мэдээллийн сан, хяналтын нэгдсэн сүлжээг үрдүүлэх, сэргээн засварлах төслүүд хэрэгжүүлэх үрэг бүхий Соёлын өвийн төвийг 1996 оноос зохион айгуулан ажиллуулж байгаа нь дээрх үйл ажиллагаанд эхих хувь нэмрээ өгч байна.

Түүх, соёлын дурсгалт зүйлийг хадгалж хамгаалах, эргээн засварлах, судлан шинжлэх, сурталчлахад шаар-агдах хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах сан"-г 1995

оноос байгуулан ажиллуулж байгаа нь энэ ажил цааш өргөжин, санхүүгийн эх үүсвэртэй болоход ач хо богдолтой боллоо. Сан нь түүх, соёлын дурсга зүйлийг хамгаалах, сэргээн засварлах төслүүди сонгон шалгаруулан санхүүжүүлж тодорхой үр дүнд хү байна.

Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах хуули монгол улсын нутаг дэвсгэрт орших түүх, соёлын хөдлөх дурсгалын эрх зүйн хамгаалалтыг улс, ор нутаг, байгууллагын гэж ангилсан юм. Үүний даг Монгол Улсын Засгийн газрын 1994 оны 233 дуга тогтоолоор "Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад ба түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт"-ыг бата улсын хамгаалалтад 93 дурсгал, аймаг, нийслэли хамгаалалтад 287 дурсгал оруулж энэ жагсаалт ороогүй түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудыг су дүүргийн Засаг даргын Тамгын газар бүртгэлдээ а хамгаалах журмыг тогтоосон юм.

Засгийн газрын хэмжээнд батлагдсан 262,1 с төгрөгийн төсөвт өртөг бүхий 1996-2000 онд хэрэ жүүлэх "Эрдэнэзуу" төслийг 1996 оноос хэрэгжүүл ЮНЕСКО, Монголын Засгийн газар, Японы Засгийн газ хамтран "Монголын эртний нийслэл Хархорум хотын ту рийг хамгаалах нь" төслийг 1995-1998 онд хэрэгжүүл төслийн үр дүнд Хархорум хотын туурьт геофизики судалгаа хийж байршлын зургийг гарган Хархорум хот хамгаалалтын бүсийг тогтоож Монгол Улсын Засги газар баталгаажууллаа. Мөн Гэгээрлийн яам Турк улс Олон улсын хамтын ажиллагааны агентлагтай хамтр 1997-2001 онд хэрэгжүүлэх "Монгол дахь Түрэгийн үе зарим хөшөө дурсгалыг хадгалж хамгаалах, судла сэргээн засварлах" төслийн ажлыг 1997 оноос эхэллэ Түүнчлэн Монголын соёлын болон байгалийн өви "Дэлхийн өвийн жагсаалт"-ад бүртгүүлэх төсөл, "Монг улсын нутаг дахь түүх, соёлын дурсгал" толь бичги хэвлэлд бэлтгэх төслийг 1996 оноос хэрэгжүүлж байн Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах, сэрг засварлах талаар төр, засгаас бодлоготой арга хэмж авсаар байгаа боловч хөтөлбөрийн хэмжээнд бодло зорилтыг тодорхойлон дэс дараатай арга хэмжээ ав шаардлагатай гэж үзэж байна.

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг хамгаал талаар урьдчилан судалж тогтоосон хөтөлбөр, төлө лөгөөгүй явж ирснээс үнэт дурсгалууд байгалийн бо

ий нөлөөнөөс үүдэн эвдэрч гэмтэх, нурж унах, устаж й болох, алдагдах явдал байнга гарч байна.
[аашид түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах удлыг онцгойлон үзэж тууштай, тогтвортой бодлого улахгүй бол дээрх байдал үргэлжлэх аюултай байна.
Түүх, соёлын дурсгалыг сэргээн засварлах ажил нь жлэх ухаан, технологийн өнөөгийн түвшинд хүрээгүй, гэжлийн боловсон хүчин, материаллаг бааз, эрдэм жилгээ, судалгааны ажил, хөрөнгө мөнгөний дутаас уг ажлыг технологийн дагуу гүйцэтгэж чадахгүй на. Түүх, соёлын дурсгалт барилгын үндсэн хийц ох модыг 2-3 жилийн нөөцтэй бэлтгэж хатааж эвсрүүлахгүй, нойтон мод хэрэглэдгээс сэргээн варлах горим зөрчигдөж уг ажил нь огт үр дүнгүй эхоос гадна үндсэн хийцдээ ч муугаар нөлөөлөх болж на.
үүнчлэн иргэдэд түүх, соёлын дурсгалт зүйлээрээ архах, хамгаалах сонирхол, мэдлэг дутмаг, орон гийн төрийн захиргааны төв байгууллагын эрх бүхий үүс нь хууль, журмаар хүлээсэн үүргээ үл биелүүл- болон түүх, соёлын үл хөдлөх дурсгалууд нь цаг арын эрс тэс уур амьсгалтай нөхцөлд байдаг, төв эин газраас алслагдсан, зам харгүй, харуул гаалалт байхгүй зэрэг нь байдлыг бүр ч хүндрүүлж гаа билээ.
дгээр нь түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг гаалах, сэргээн засварлах тодорхой бодлого нэн гамдсан болохыг илэрхийлж байна.

### Хоёр. Хөтөлбөрийн зорилго

одорхой бодлого, дэс дараалалтайгаар түүх, соёлын эгалыг хамгаалах, сэргээн засварлах ажлыг гүйцэт- түүх, соёлын дурсгалын өнөөгийн байдал, хэтийн эвийг тодорхойлох, аялал жуулчлалын маршрутад улах, түүх, соёлын дурсгалыг хамгаалах, сэргээн варлахад зарцуулж буй төсвийн хөрөнгө, олон улсын гууллага, хандивлагч орнуудын зээл, тусламжийг аас төлөвлөсөн бодлого зорилготой, үр бүтээлтэй улахад Үндэсний хөтөлбөрийн зорилго оршино.
үний үр дүнд Монгол Улсын Засгийн газрын үйл илагааны хөтөлбөрт "Монголын түүх, соёлын үл нөх дурсгалуудыг хамгаалах, сэргээн засварлах өлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ" гэсэн заалт эгжих боломцоо бүрдэнэ.

## Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй

### А. Дурсгалуудыг гэмтээж буй хүчин зүйл

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалууд нь дор дурдса хүчин зүйлүүдээс болж гэмтдэг. Үүнд:

1. Байгалийн хүчин зүйл, нөлөөлөл:

-ил задгай газар оршиж буй түүх, соёлын үл хөдлө дурсгалууд нь нар, салхи, ус, чийг, агаарі температурын өөрчлөлт зэргээс шалтгаалан хагаі гэмтэх, хуурч унах, үйрч бутрах байдлаар анхны хэлб төрхөө алдаж, үсэг зурлага, чимэглэл нь бүдгэі гэмтэх;

-байгалийн гэнэтийн үзэгдэл газар хөдлөх, үеі аянга, цахилгаан, гал түймрийн нөлөөгөөр хугаі ойчих, нурж унах, шатах, устаж үгүй болох.

2. Биологийн процесс:

-шувууны сангасанд бохирдож, түүний нөлөөгө хөшөө чулууны бүтэц өөрчлөгдөн үйрч гэмтэх;

-шувууны сангасны нөлөөгөөр дурсгалт барилгууд гадна болон дотор талын хээ угалз, чимэглэл, өн будгийн анхны төрх байдал алдагдаж гэмтэх;

-модон дурсгалт барилгыг хортон шавьж идэ мөөгөнцөр гэмтээх.

3. Хүний буруу үйл ажиллагаа:

-сүг зурагтай хад, булш хиргисүүр, байшин барилг туурийн чулууг зөөж малын хашаа хороо барих, барилг суурь хийх зэргээр устгаж үгүй хийх;

-хадны сүг зураг, хөшөө дурсгалыг үзэж сонирхс зарим хүмүүс өөрсдийн нэр, хаяг, он, сар, өдөр бич дахин сэргэшгүй сүйтгэл учруулах;

-олз ашиг хайсан хүмүүс булш хиргисүүр, бунха ухаж сүйтгэх;

-хөшөө дурсгалыг унаган газар нутгаас нь зө түүхэн ач холбогдлыг нь алдагдуулах;

-археологичид малтлага хийсний дараа уг газр цэвэрлэж тохижуулаагүйгээс онгорхой нүх, э замбараагүй чулуу болж үлдэх;

-хөшөө дурсгалыг хамгаалж барьсан хашаанд ма адуугаа хашдаг учраас мал хөшөөг шөргөөж хир, т болгох, унагах, хашааг эвдэж нураах;

-сэргээн засварлахдаа сэргээн засварлах ажл үндсэн зарчмыг зөрчих, чанаргүй гүйцэтгэх.

### В. Дурсгалыг хамгаалах арга

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлүүд эвдэ гэмтэн, устаж үгүй болоход нөлөөлж буй дээрх хүч зүйлүүдийг зогсоох дараахь аргууд байна. Үүнд:

1. Бүртгэх:
-Улс, орон нутаг, байгууллагын хамгаалалтад байгаа ух, соёлын үл хөдлөх дурсгал, түүх, соёлын дурсгалт эрүг Түүх, соёлын дурсгалт зүйлийн улсын нэгдсэн этгэл-мэдээллийн санд тусгай маягтын дагуу бүртгэн байршлыг нь нарийвчлан тогтоох, эрдэм шинжил-эний тодорхойлолтыг нь бичих, гэрэл зураг, дүрс илэгээр баяжуулах зэргээр уг дурсгалын талаар иж эн баримт материал цуглуулах;
-Түүх, соёл, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогд-эроо монголдоо төдийгүй дэлхийн түүх, соёлын шгүй хэсэг болсон дурсгалуудыг "Дэлхийн соёлын юн байгалийн өвийн жагсаалт"-ад бүртгүүлэх ажлыг ион байгуулах.
2. Хамгаалалтад авах:
-Түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудыг газар дээр нь ж судалсны үндсэн дээр шинээр хамгаалалтад авч, с, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, лын үл хөдлөх дурсгалын жагсаалт"- ад өөрчлөлт улах саналыг боловсруулах;
-Хамгаалалтын бүс тогтоох;
-Хашаа, саравч барьж болохгүй том хэмжээний цолбор дурсгал, булш, хиргисүүр зэргийг орчин ронтой нь дархлан хамгаалж "Тусгай хамгаалалттай ар нутгийн тухай хууль"- ийн дагуу улсын тусгай гаалалттай дурсгалт газар болгон хамгаалалтад х.
3. Сурталчлах:
-Түүх, соёлын дурсгалын үнэ цэнэ, ач холбогдлыг н түмэнд сурталчлах, сургуулийн сургалтын хөтөл-т тусгах зэргээр ард нийтээр эрхэмлэн хайрлаж гаалдаг болгох;
-Түүх, соёлын дурсгалын талаар радио, телевиз, ин хэвлэл зэрэг олон нийтийн хэвлэл мэдээллийн эгслээр сурталчлах;
-Түүх, соёлын дурсгалт зүйлийн лавлах, толь бичиг, , танилцуулга, газрын зураг зэргийг хэвлүүлэн талчлах.
4. Консерваци хийх:
Түүх, соёлын дурсгалыг өнөө үе хүртэл хадгалагдаж эн байдлыг хэвээр нь хамгаалж бэхжүүлэн цаашид ж унахыг зогсоож, үзмэр болгон тохижуулан глахад консервацийн ажлын гол зорилго оршино.
Консервацийн ажилд дараах зүйлийг багтаана:

-хөшөө дурсгалыг элдэв бохирдлоос цэвэрлэх, орч
тохижуулах;

-дурсгалуудад пайз тэмдэг тавьж, хашаа хайс ба
хамгаалах;

-байгаль, цаг уурын нөлөөллөөс хамгаалах, ду
галын хийц, бүтээц, материалыг бэхжүүлэх;

-түр бэхэлгээ хийх;

-саравч барих.

Туурь, суурь нь үлдсэн дурсгалт барилгын үл
эсвэл археологийн малтлагаар илэрсэн байгуулам
консервацийн ажил онцгой шаардлагатай. Консерва
аргаар бэхжүүлж хамгаалсан дурсгалт барилгын үл
туурь зэргийг үзмэр буюу ил музей байдлаар ашигла
тулд сахиул, тайлбарлагчийн байр, археоло
олдворыг үзмэр болгон хадгалах байр, түр а
сандал, сүүдрэвч, автомашины зогсоол зэр
төлөвлөнө.

5.Сэргээн засварлах:

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг сэр
засварлах ажил нь хэсэгчилсэн сэргээн засварла
бүтнээр нь сэргээн засварлалт гэсэн 2 аргаас бүрд
Хэсэгчилсэн сэргээн засварлах арга нь консерва
өргөтгөсөн хэлбэр юм. Дурсгалт зүйлийн тала
түүхэн баримт, газар дээр хийсэн судалгаа
тодорхой, анхны төрх байдлаар нь сэргээн засва
боломжтой нөхцөлд бүтнээр нь сэргээн засва
аргыг хэрэглэнэ.

Дурсгалт зүйлийн түүх, соёлын ач холбог
батлатган, түүхэн үнэ цэнийг тодорхойлон, уран са
шинж төрхийг нь алдагдуулалгүйгээр эх матер
баримтыг эрхэмлэн анхны төрх байдлаар сэргээн бос
хийц хэсэглэлүүдийг бэхжүүлэхэд сэргээн засва
ажлын гол зорилго оршино. Сэргээн засварлах а
түүхэн баримт бичиг, хэмжилт судалгаа, сэр
засварлах ажлын зургийг бүрэн боловсруулсан үн
дээр "Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах хуу
ийн дагуу мэргэжлийн байгууллага гүйцэтгэнэ.

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг хад
хамгаалах, сэргээн засварлах ажлыг гүйцэ
мэргэжлийн байгууллага нь олон улсын хэмжээнд мө
буй сэргээн засварлах ажлын зарчим буюу "Х
дурсгал, дурсгалт газрыг хадгалж хамгаалах, сэр
засварлах тухай олон улсын Харти"-ийг мөрд
болгоно.

## Дөрөв. Хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөлт

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг хадгалж мгаалах, сэргээн засварлах хөтөлбөрийг 7 хэсэгт ваан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахаар төлөвлөх йна. Ингэж төлөвлөхдөө захиалагч байгууллага, рэгжүүлэх хугацааг тодорхойлон шаардагдах хөрөнгийн эмжээг урьдчилан тогтоож байна. Тухайн үеийн эдийн згийн нөхцөл байдлаас хамаарч энэхүү төлөвлөгөөнд дотгол хийж байх болно.



# ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙГ ХАДГАЛЖ ХАМГААЛАХ, СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ /1999- 2005 ОН /

Нэг. Сэргээн засварлах дурсгалууд

| д/д | Дурсгалын нэр | Сэргээн засварлах хугацаа | Төсөвт өртөг сая/төг | Хариуцах байгууллага /захиалагч/ | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1. | **Архангай аймаг.** Эрдэнэбулган сум. Заяын гэгээний хийдийн Цогчин дуган | 1999-2001 | 120.0 | Гэгээрлийн яам, Аймгийн ЗДТГ | Цогчин дуганыг сэргээн засварлах зураг төсөв нь хийгдсэн. |
| 2. | **Баянхонгор аймаг** Галуут сум. Чин сүжигт Номун хан (мандал)-ы хийд | 1999-2005 | 130.0 | Гэгээрлийн яам, Аймгийн ЗДТГ | Сүсэгтнүүд нь сэргээн засварлаж эхэлсэн. |
| 3. | **Өвөрхангай аймаг** Хархорин сум. Эрдэнэзуу хийд | 1996-2000 | 262.1 | Гэгээрлийн яам | 1996-2000 онд хэрэгжүүлэхээр батлагдсан "Эрдэнэзуу" төслийн хүрээнд сэргээн засварлаж байна. |
| 4. | Бат-өлзий сум. Төвхөн хийд | 1999-2000 | 15.0 | Гэгээрлийн яам, Аймгийн ЗДТГ | Соёлын сангаас санхүүгийн дэмжлэг үзүүлж сэргээн засварлах ажлыг хийж эхэлсэн. |
| 5. | Хархорин сум. Баруунхүрээ /Шанх/-ний Цогчин дуган | 1999-2000 | 18.0 | Гэгээрлийн яам | Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах сангаас санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 6. | **Өмнөговь аймаг** Номгон сум. Сангийн далай хийд | 1999-2002 | 180.0 | Аймгийн ЗДТГ | Үлдэгдэл дурсгалыг сэргээн засварлах |
